



ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН | 2021 ОНЫ ХАГАС ЖИЛ

*Аудитыг цахимжуулж нэгтгэн удирдах тогтолцоог,
бүрдүүлэн төлөвшүүлэх жил*

**ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар	2
БҮЛЭГ 1. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ	3
Бүтэц, зохион байгуулалт	3
Аудитын үйл ажиллагаа	4
БҮЛЭГ 2. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ	7
Санхүүгийн тайлангийн аудитын үр дүн	8
Санхүүгийн тайлангийн аудитын үр нөлөө	9
ТЕЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудит	9
ТЕЗ-ийн 2020 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	10
“Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуульд оролцож байгаа нам, эвсэл, нэр дэвшигч сонгуулийн зардлын тайлан гаргах, зардлын тайланд хийсэн аудит	11
БҮЛЭГ 3. ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТ	12
Гүйцэтгэлийн аудитын үр дүн	12
Гүйцэтгэлийн аудитын үр нөлөө	13
Улсын төсвийн 2020 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг	14
Орон нутгийн төсвийн 2019-2020 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг	15
БҮЛЭГ 4. НИЙЦЛИЙН АУДИТ	16
Нийцлийн аудитын үр дүн	17
Нийцлийн аудитын үр нөлөө	17
Иргэн, хуулийн этгээдэд газар эзэмшүүлэх, ашиглуулах шийдвэр, үйл ажиллагаа нь Газрын тухай хуульд нийцсэн эсэх	17
БҮЛЭГ 5. НЭГДСЭН УДИРДАМЖААР ХИЙХ АУДИТЫН ТӨЛӨВЛӨЛТИЙН ӨМНӨХ ҮЕ ШАТ	18
БҮЛЭГ 6. ӨӨРИЙН САНААЧИЛГААР ХИЙСЭН АУДИТ	19
БҮЛЭГ 7. ДОТООД АЖИЛ	19
Дотоод сургалт	19
ҮАГ-аас хийсэн сургалт	20
Бусад сургалт	20
Хамтын ажиллагаа	20
Мэдээлэл сурталчилгаа	21
Албан харилцаа	22
Өргөдөл гомдол	23
Шагнал урамшуулал	24
Шинэ санаачилга	24
Нууцын хадгалалт, хамгаалалт	25
Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх	25
Цаг үеийн шинжтэй гүйцэтгэсэн нэмэлт ажлууд	26
Мэдээллийн технологи	28
БҮЛЭГ 8. САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛ ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	29
БҮЛЭГ 9. ДҮГНЭЛТ, ЦААШДЫН ЗОРИЛТ	30
БҮЛЭГ 10. САНАЛ, САНААЧИЛГА	31

Товчилсон үгийн тайлбар

МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
ҮАГ	Үндэсний аудитын газар
ТАБ	Төрийн аудитын байгууллага
ТАГ	Төрийн аудитын газар
ЗУГ	Захиргаа удирдлагын газар
ХШУДАГ	Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар
СХОХ	Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтэс
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ТБОНӨААН	Төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгж
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
СТОУС	Санхүүгийн тайлангийн олон улсын стандарт
НББОУС	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
СТАУС	Санхүүгийн тайлангийн аудитын удирдлагын систем
ТА	Тэргүүлэх аудитор
УИХ	Монгол Улсын Их хурал
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ТГ	Тамгын газар
АТГ	Авлигатай тэмцэх газар
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТВ	Телевиз
ХХК	Хязгаарлагдмал хувьцаат компани
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
МТ	Мэдээллийн технологи
ХАСХОМ	Хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлэг

1. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газар нь 2021 онд ТАБ-ын хэмжээнд дэвшүүлсэн “Аудитыг цахимжуулж нэгтгэн удирдах тогтолцоог бүрдүүлэн төлөвшүүлэх жил”-ийн хүрээнд Газрын 2021 онд хэрэгжүүлэх гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулан МУЕА-ын орлогчийн үүргийг түр орлон гүйцэтгэгч болон Тамгын даргаар батлуулан ажиллалаа.


Төлөвлөгөөг “Төрийн аудитын байгууллагын 2019-2024 онд хэрэгжүүлэх стратеги”, “Харилцагч талуудын оролцооны стратеги”, “ТАБ-ын үйл ажиллагаанд иргэдийн оролцоог хангах стратеги” болон УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2020 оны аудитын сэдэв батлах тухай 05, 2020 оны 04 дүгээр тогтоолууд, МУЕА-ын 2021 оны А/28 тушаалаар батлагдсан “Төрийн аудитын байгууллагын 2021 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө”, ТАБ-ын Гүйцэтгэлийн төлөвлөгөөг үндэслэн боловсрууллаа.

Эхний хагас жилийн байдлаар гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан аудит болон дотоод үйл ажиллагаатай холбоотой ажлуудыг бүрэн хэрэгжүүллээ.

Бүтэц, зохион байгуулалт


МУЕА-ын 2021 оны А/02 тушаалаар баталсан бүтэц, орон тооны дагуу 12 албан хаагчтай үндсэн үйл ажиллагааг хэрэгжүүлэх болон дэмжих үйлчилгээний нэгжийн зохион байгуулалтаар үйл ажиллагаагаа явуулж байна.

Схем №1. “Газрын бүтэц, зохион байгуулалт”




Хүний нөөц


Ажилласан жилээр:




Насны бүтцээр:



Мэргэжил, мэргэшил:



Боловсролын зэрэг:



Төрийн аудитын газрын албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг сайжруулах чиглэлээр:

- “Хүүхдийн эрхийг хамгаалах өдөр”-ийг тохиолдуулан албан хаагчдын 18-аас доош насны 16 хүүхдэд 320,0 мянган төгрөгийн бэлэг
- Цар тахлаас сэргийлэх, дархлааг сайжруулахад 701,1 мянган төгрөгийн дэмжлэгийг үзүүлсэн.

Аудитын үйл ажиллагаа

Төрийн аудитын газар нь 2021 оны эхний хагас жилийн байдлаар 174 аудитыг гүйцэтгэж, үүнээс Санхүүгийн тайлангийн аудитаар орон нутагт үйл ажиллагаа явуулж буй бүх шатны төсөв захирагчдын төсвийн гүйцэтгэл болон санхүүгийн тайланд 171 бие даасан дүгнэлт гаргасан байна. Гүйцэтгэлийн 2 аудитад 36, нийцлийн 1 аудитад 16 байгууллага, нэгжийн үйл ажиллагааг тус тус хамруулсан байна. (Дүрслэл 1)

Дүрслэл 1. Гүйцэтгэсэн аудит



Дүрслэл 2. Аудитын илрүүлэлт



Гүйцэтгэсэн аудитын дүнгээр нийт 265,233.1 сая төгрөгийн 617 алдаа, зөрчил илрүүлж (Дүрслэл 2), тэдгээрийн 4.0 хувь буюу 10,581,2 сая төгрөгийн алдааг аудитын явцад залруулж, нийт 56.0 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 249,049.2 сая төгрөгийн албан шаардлага, 73 зөвлөмж, 2 хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлж ажиллалаа.



Санхүүгийн тайлангийн болон гүйцэтгэл, нийцлийн аудитын 5 жилээр харьцуулсан гүйцэтгэлийн үзүүлэлтийг харууллаа.

Дүрслэл 3. “Гүйцэтгэсэн аудитад хамрагдсан байгууллагууд (тоон харьцуулалт)



Төрийн аудитын газар нь 2021 оны эхний хагас жилийн байдлаар улс, орон нутгийн төсөвт 74.9 сая төгрөгийг төвлөрүүлж, нийт 5,941.8 сая төгрөгийн үр өгөөжийг аудитад хамрагдсан байгууллагаар хүлээн зөвшөөрүүлсэн нь төсвөөс авсан санхүүжилтийн 1 төгрөг тутамд 28.1 төгрөгийн үр өгөөжийг бий болгосныг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2.3 дахин өссөн үзүүлэлттэй байна.


Дүрслэл 4. Аудитын үр нөлөө



Аудитын илрүүлэлтийн 25,062.4 сая төгрөг буюу 9.4 хувийг нягтлан бодох бүртгэл, тайлагналтай, 4,927.5 сая төгрөг буюу 1.9 хувийг төсвийн төлөвлөлт гүйцэтгэлтэй, 227,203.8 сая төгрөг буюу 85.7 хувийг хууль тогтоомжийн хэрэгжилттэй, 2,521.1 сая төгрөг буюу 1.0 хувийг худалдан авалттай, 4,577.1 сая төгрөг буюу 1.7 хувийг дотоод хяналт, хариуцлагатай, 385.0 сая төгрөг буюу 0.1 хувийг арвилан хэмнэлт,

үр ашиг, үр нөлөөтэй, 556.2 сая төгрөг буюу 0.2 хувийг бусад асуудалтай холбоотой зөрчил эзэлж байна.

Дүрслэл 5. Аудитын илрүүлэлт, алдаа зөрчлийн ангилал




Төлбөрийн акт: Тайлант хугацаанд 56.0 сая төгрөгийн 67 төлбөрийн акт тогтоосон байна. Тайлант онд тогтоосон актаас 17.0 сая төгрөгийг, өмнөх оны үлдэгдлээс 57.9 сая төгрөгийг барагдуулж, хууль хяналтын байгууллагад 5,610.3 сая төгрөгийн актыг шилжүүллээ. Өмнөх оны 12.2 сая төгрөгийн нийт 51.2 сая төгрөгийн актын үлдэгдэлтэй байгаагийн 39.0 сая төгрөгийн актын төлөгдөх хугацаа болоогүй байна. (Дүрслэл 6)


Албан шаардлага: Тайлант хугацаанд 249,049.2 сая төгрөгийн 387 албан шаардлага хүргүүлсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 10.7 дахин өссөн үзүүлэлттэй байна. Тус албан шаардлагаас 22,268.9 сая төгрөг, өмнөх оны албан шаардлагын үлдэгдлээс 223.9 сая төгрөг нь хэрэгжиж, нийт 220,607.7 сая төгрөгийн албан шаардлагын хугацаа болоогүй байна. (Дүрслэл 7)

Зөвлөмж: Тайлант хугацаанд 73 зөвлөмж өгснөөс 40, өмнөх оны үлдэгдэл 19 зөвлөмж бүрэн хэрэгжиж, хугацаа хэтэрсэн зөвлөмж байхгүй байна. (Дүрслэл 8)


Дүрслэл 6. Төлбөрийн акт (сая төгрөг)



Дүрслэл 7. Албан шаардлага (сая төгрөг)



Дүрслэл 8. Зөвлөмж (Тоо)




2. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ


Төсөв захирагчид нь санхүүгийн тайлангаа нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн зарчмууд болон СТОУС, НББОУС-д нийцүүлэн үнэн зөв тайлагнасан эсэхэд АДБОУС, МУЕА-ын баталсан ТАБ-ын санхүүгийн тайлангийн аудитын журам, ерөнхий чиглэлийн хүрээнд Төсвийн хуульд заасан цаглабарт хугацаанд санхүүгийн тайлангийн аудит хийж 74.1 сая төгрөгийн өртөг, 2800 хүн /өдөр зарцууллаа.

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Хамрагдсан байгууллага 227



Аудитын санал дүгнэлт 171



Аудитын илрүүлэлт – 254,524.5

Залруулсан -10,581.2

Залруулагдаагүй – 243,943.3



- Төлбөрийн акт - 56.0 сая төгрөг
- Албан шаардлага - 242,876.6 сая төгрөг
- Зөвлөмж - 1,010.7 сая төгрөг



56.0 сая/төг
Акт




242,876.6 сая/төг
Албан шаардлага



1,010.7 сая/төг
Зөвлөмж

Эхний үлдэгдэл | Тайлант онд тогтоосон | Хэрэгжсэн | Хуулийн байгууллагад шилжүүлсэн | Үлдэгдэл



Эх сурвалж: Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын 2021 оны эхний хагас жилийн статистик мэдээ

Санхүүгийн тайлангийн аудитын үр дүн

Тайлант онд хуулиар тогтоосон чиг үүргийнхээ дагуу улс, орон нутгийн төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит этгээд, төсөл хөтөлбөрийн 227 санхүүгийн тайланд аудит хийхээс 171 байгууллагад бие даан дүгнэлт гаргаж, 8 байгууллагад итгэл үзүүлж, 48 тайланг түүвэрт хамруулж ажиллалаа.


Санхүүгийн тайлангийн аудитаар 171 байгууллагын санхүүгийн тайланд өгсөн санал дүгнэлтийн 165 буюу 96.5 хувьд зөрчилгүй, 5 буюу 3.0 хувьд хязгаарлалттай, 1 байгууллагад санал дүгнэлт өгөхөөс татгалзсан.

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 254,524.5 сая төгрөгийн алдаа зөрчил илрүүлснээс 10,581.2 сая төгрөгийн 89 алдаа зөрчлийг санхүүгийн тайланд залруулсан. Аудитаар залруулагдаагүй 56.0 сая төгрөгийн 67 зөрчилд төлбөрийн акт, 242,876.6 сая төгрөгийн 371 зөрчилд албан шаардлага, 1,010.7 сая төгрөгийн 64 зөрчилд зөвлөмж өгч ажиллалаа. Тайлант онд тогтоосон 56.0 сая төгрөгийн болон өмнөх оны үлдэгдэл 17.1 сая төгрөгийн төлбөрийн актаас 2021 оны 06 дугаар сарын 15-ны байдлаар нийт 32.5 сая төгрөгийн актыг барагдуулж төсөвт төвлөрүүллээ.


Мөн 22,268.9 сая төгрөгийн 177 албан шаардлага, 543.6 сая төгрөгийн 40 зөвлөмжийн биелэлтийг хангуулан ажиллаад байна.

Аудитаар тогтоосон хугацаанд барагдуулаагүй 11.8 сая төгрөгийн 3 төлбөрийн актыг Прокурорын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх “Прокурор төрийн ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзвэл төрийн байгууллагын хүсэлтээр, нийтийн ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзвэл төрийн байгууллагын хүсэлт, эсхүл өөрийн санаачилгаар захиргааны болон иргэний хэрэг шүүхээр хянан шийдвэрлэх ажиллагаанд зохигчоор, эсхүл гуравдагч этгээдээр оролцоно” гэсэн заалтын дагуу нэхэмжлэн хууль хяналтын байгууллагад шийдвэрлүүлэхээр хүргүүлээд байна. Тайлант оны үлдэгдэл төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийн биелэлтийг хангуулах хугацаа болоогүй байна.

Санхүүгийн тайлангийн аудит нь богино хугацаанд төсөвт байгууллагын бүтэн жилийн санхүүгийн тайланд аудитын стандартад заасны дагуу 95 хувийн баталгааны түвшинд дүгнэлт өгөх аудит юм.



2021 оны 01 дүгээр сарын 25-ны байдлаар



2021 оны 02 дугаар сарын 21-ний байдлаар

Бид аудитыг хуульд заасан хугацаанд нэг арга зүйгээр чанартай гүйцэтгэхийн тулд үе шатны ажлуудад хугацааг оновчтой хуваарилах, аудаторуудын ажлын гүйцэтгэлийг СТАУС программд тасралтгүй жигд оруулан, хянаж баталгаажуулахад анхаарч ажилладаг.

Санхүүгийн тайлангийн аудитын үр нөлөө

Санхүүгийн тайлангийн аудитыг орон нутаг дахь бүх шатны төсөв захирагчид, санхүүгийн ажилтнуудыг оролцуулан хийж, аудит хийх багийн бүрэлдэхүүн, аудитаар баримтлах бодлого, чиглэл, үүрэг хариуцлагыг танилцуулж нээдэг болсноор шалгадагч байгууллагуудын аудитын үйл ажиллагаанд оролцох хариуцлага, хандлага сайжирсан.

Тайлант оны санхүүгийн тайлангийн аудитад хэрэгжүүлэх горим сорилыг, илэрч байсан алдаа зөрчлүүдэд хийсэн судалгааг үндэслэн өмнөх оны 8 дугаар сард тогтоон Тэргүүлэх аудиторар батлуулж, уг чиглэлийн дагуу өөрийн аудаторууд болон ХАК-ийн аудаторуудыг хамруулан дотоод сургалтыг зохион байгуулж ирсэн. Ингэснээр аудаторууд ижил асуудлаар нэг цаг хугацаанд адил шийдэл гаргах нөхцөлийг бүрдүүлж, илэрсэн зөрчлийн шинж чанар, хамрах хүрээг үнэлэн цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлоход ач холбогдолтой байна.

Аймгийн хэмжээнд төсөв захирагчдын төрлөөр аудитын дүн, цаашид анхаарах асуудлын талаар нэгдсэн танилцуулгыг жил бүр хийснээр төсвийн хөрөнгийн зарцуулалт, түүнд тавих хяналт сайжирч, материаллаг шинж чанартай алдаа зөрчил буурч байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 1,134.7 сая төгрөгийн 150 санхүүгийн үр өгөөжийг бүртгэн, шалгадагч байгууллагаар хүлээн зөвшөөрүүлж баталгаажууллаа.

ТЕЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудит


Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 152 төсвийн байгууллага, 17 орон нутгийн өмчит аж ахуйн нэгж, 14 төсвийн төвлөрүүлэн захирагч, 1 тусгай сан, нийт 184 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс

131 байгууллагад дүгнэлт гаргаж, 6 байгууллагад итгэл үзүүлэн, 47 байгууллагыг түүвэрт хамруулсан байна.



177,944.3 сая төгрөг
ОНТЕЗ нийт алдаа зөрчил

Аудитаар нийт 177,944.3 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 888.3 сая төгрөгийн алдааг залруулж, 174,725.5 сая төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага, өгч ажиллалаа. ТЕЗ-ын нэгтгэсэн тайланд “Зөрчилгүй” санал дүгнэлт өгч аудитын тайлан дүгнэлтийг аймгийн Засаг дарга болон ҮАГ-ын Аудитын 2-р газарт хүргүүлсэн.



ТЕЗ-ийн 2020 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит

Төсвийн тухай хуулийн 8.9.4-т заасны дагуу Дорнод аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайланд тусгагдсан нийт орлого ба тусламжийн 73,273.6 сая төгрөг, нийт зарлага ба цэвэр зээлийн 71,886.7 сая төгрөгийн гүйцэтгэлийг баталгаажуулж дүгнэлт гаргалаа.

Аудитаар илэрсэн 2,330.5 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага, дотоод хяналтыг үр дүнтэй, цаг хугацаанд зохион байгуулж ажиллах 1 зөвлөмж өгч, МУ-ын нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайланд тусгуулах 2 саналыг ҮАГ-т уламжлан аудитын тайланг дарга, Тэргүүлэх аудиторын тушаалаар баталгаажуулж хугацаанд нь аймгийн ИТХ, Засаг дарга болон ҮАГ-ын Аудитын 2-р газарт хүргүүлсэн. Мөн иргэд олон нийтийг мэдээллээр хангах зорилгоор аудитын тайланг audit.mn сайтад байршуулж ажиллалаа.

Дорнод аймгийн ТЕЗ-ийн 2020 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргасан.



Эерэг үр нөлөө

Аймгийн 2020 оны төсвийн нийт орлого төлөвлөгөөнөөс 10.8 хувь буюу 2,710.5 сая төгрөгөөр давж биелсэн байна.

Тайлант онд улсын төсөвт 199.6 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлсэн байна.



Сөрөг үр нөлөө

Санхүүгийн хяналт, аудитын албаны хийж байгаа хяналт нь цаг хугацааны хувьд оновчтой бус байгаагаас үр дүнд нөлөөлж байна.

ТЕЗ-ын 2019 оны нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайланд Дорнод аймаг дахь Төрийн аудитын газраас хийсэн аудитаар өгсөн 2 зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулаагүй байна.



Аймгийн төсвийн суурь зардлыг Сангийн яамнаас тогтоосон хязгаараас хэтрүүлэн төлөвлөж, зарцуулсан нь Сангийн яам Төсвийн хязгаарыг хянахдаа сумдын нөөц хөрөнгө болон төсөвт байгууллагуудын орон тоог улсын хэмжээн дэх жишиг үзүүлэлтийг харгалзан бодитой тооцохгүй байгаатай холбоотой байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсөвт хамаарах хөтөлбөр, арга хэмжээний 7.7 хувь хэрэгжээгүй нь татварын бус орлого гэрээний хугацаандаа ороогүйгээс шалтгаалсан байна.

“Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуульд оролцож байгаа нам, эвсэл, нэр дэвшигч сонгуулийн зардлын тайлан гаргах, зардлын тайланд хийсэн аудит

“Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуульд оролцож байгаа нам, эвсэл, нэр дэвшигч сонгуулийн зардлын тайлан гаргах, зардлын тайланд аудит хийх, хянах, дүнг нийтэд мэдээлэх, танилцуулах журам”-ыг дарга бөгөөд Тэргүүлэх аудиторын 2020 оны 23 тоот тушаалаар батлуулж нам, эвслээс оруулсан хөрөнгө, иргэн, хуулийн этгээдээс авсан хандив түүний зарцуулалтын тайланг шалгаж хугацаанд нь чанартай хийж гүйцэтгэлээ.

Аудитаар илэрсэн аймаг, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуульд оролцсон сонгуулийн зардлын тайланг ирүүлээгүй нам, нэр дэвшигчийн нэрсийн жагсаалтыг аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэст 2021 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн 03 тоот албан бичгээр хүргүүлсэн.

Аудитыг “Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль”-ийн 57 дугаар зүйлийн 57.1-д заасны дагуу 2021.01.15-ны өдөр audit.mn болон байгууллагын албан ёсны фэйсбүүк хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлж ажиллалаа.



3. ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТ

Төрийн аудитын газар нь шалгагдаж буй байгууллагыг чиг үүргээ хэрэгжүүлэхдээ өөрийн нөөцийг арвиг хямгач, үр ашигтай, үр нөлөөтэй ашиглаж байгаа эсэхэд АДБОУС, Төрийн аудитын стандарт, МУЕА-ын "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам", "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам", гарын авлагын хүрээнд аудит хийж, 36.8 сая төгрөгийн өртөг, 368 хүн/өдөр зарцууллаа.


ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ



2
Аудит
гүйцэтгэсэн



36
Байгууллагыг
хамруулсан



Эх сурвалж: Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын 2021 оны эхний хагас жилийн статистик мэдээ

Гүйцэтгэлийн аудитын үр дүн

ҮАГ-ын нэгдсэн удирдамжаар болон газрын бодлого шийдвэрийн хүрээнд өөрийн төлөвлөгөөгөөр, төсвийн хөрөнгийн зарцуулалт, төсөл хөтөлбөрийн хэрэгжилтэд гүйцэтгэлийн аудит хийж арвилан хэмнэлт, үр ашиг, үр нөлөөг сайжруулах асуудлыг нотлох баримтад тулгуурлан тайлагнаж, дүгнэлт зөвлөмжийг холбогдох байгууллагуудад хүргүүлэн ажиллалаа.

МУЕА-ын баталсан аудитын төлөвлөгөөний хүрээнд 2021 онд 5 гүйцэтгэлийн аудитыг хийхээр төлөвлөснөөс эхний хагас жилд батлагдсан 2 гүйцэтгэлийн аудитыг 36 байгууллагыг хамруулан 100 хувь хугацаанд нь хийж гүйцэтгэлээ.

Гүйцэтгэлийн аудитаар нийт 9.9 тэрбум төгрөгийн зөрчил илрүүлж 5.6 тэрбум төгрөгийн зөрчилд 11 албан шаардлага, 4.3 тэрбум төгрөгийн зөрчилд 6 зөвлөмж, нэгтгэсэн тайланд тусгуулах 6 саналыг өгч ажиллалаа.

Төрийн аудитын газраас гүйцэтгэлийн аудитаар тайлант онд өгсөн 6 зөвлөмж, өмнөх оны үлдэгдэл 15, нийт 21 зөвлөмжийн 15 нь хэрэгжиж, хугацаа болоогүй 6 зөвлөмжийн үлдэгдэлтэй байна.

Өмнөх оны үлдэгдэл 42.7 сая төгрөгийн төлбөрийн актаас 2021 оны эхний хагас жилийн байдлаар 30.9 сая төгрөгийн төлбөрийн актыг барагдуулж, 6.5 сая төгрөгийн төлбөрийн акт хуулийн байгууллагад хянагдаж байгаа бөгөөд 5.3 сая төгрөгийн төлбөрийн актын үлдэгдэлтэй байна. Үүнээс 3.9 сая төгрөгийн төлбөрийн актыг Прокурорын байгууллагад шилжүүлээд байна.

Мөн тайлант онд өгсөн 11, өмнөх оны үлдэгдэл 1 буюу нийт 12 албан шаардлагаас 1 албан шаардлага хэрэгжиж, 11 албан шаардлагын хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй байна.

Гүйцэтгэлийн аудитын үр нөлөө

ҮАГ-ын нэгдсэн удирдамжаар болон газрын бодлого, шийдвэрийн хүрээнд өөрийн төлөвлөгөөгөөр, улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын хэрэгжилтэд гүйцэтгэлийн аудит хийж арвилан хэмнэлт, үр ашиг, үр нөлөөг сайжруулах асуудлыг нотлох баримтад түшиглэн тайлагнаж, дүгнэлт, зөвлөмжийг холбогдох байгууллагад хүргүүлэн ажиллалаа.

Улсын хэмжээнд болон өөрийн санаачилгаар жил бүр давтан хийгдэж байгаа улс болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилтэд хийж буй аудитын үр дүнд алдаа зөрчлийн төрөл буурч, хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэлд тавих хяналт сайжирч байна.

Аймгийн төвийн болон 12 сумдын хөрөнгө оруулалтын ажлыг объект дээр нь биечлэн очиж, ашиглагч талын сэтгэл ханамжийг үнэлсэн.

Хөрөнгө оруулалтад хийсэн аудитаар төлөвлөлтийг тооцоо судалгаанд үндэслэхгүй, дотоод аудит цаг тухайд нь хийгдэхгүй байгаа нь хөрөнгө оруулалтын үр ашгийг бууруулж байгаа тухай дүгнэлтийг гаргасан.

Гүйцэтгэлийн аудитаар нийт 3,990.1 сая төгрөгийн үр өгөөжийг бүртгэн, шалгагдагч байгууллагаар хүлээн зөвшөөрүүлж баталгаажууллаа.

Улсын төсвийн 2020 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг

Аудитын дүн



15.4 тэрбум төгрөг
24 төсөл, арга хэмжээ



86.3%
Төсөл, арга хэмжээний гүйцэтгэл



82.1%
Санхүүжилтийн гүйцэтгэл



7,923.8 сая төгрөг
Илрүүлсэн алдаа
ЗӨРЧИЛ



Албан шаардлага 3,636.8 сая төгрөг
Зөвлөмж 4,287.0 сая төгрөг


Нэгдсэн удирдамжийн хүрээнд “Улсын төсвийн 2020 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг”-т хийх аудитын дэд төлөвлөгөө, хөтөлбөрийг батлан гүйцэтгэлийн аудитыг 2020 оны 03 дугаар сарын 18-наас 04 дүгээр сарын 29-ний хооронд хийж гүйцэтгэлээ.

Аудитад 13.3 сая төгрөгийн өртөг, 140 хүн/өдөр зарцуулан, баримт материалд дүн шинжилгээ хийх, газар дээр нь очиж үзэх, холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, тодруулга, тайлбар авах зэрэг горимуудыг хэрэгжүүлсэн.

Аудитаар нийт 7,923.8 сая төгрөгийн зөрчил илэрснээс 3,636.8 сая төгрөгийн зөрчил арилгуулах 4, хариуцлага тооцох 1 нийт 5 албан шаардлага, 4,287.0 сая төгрөгийн зөрчилд 3 зөвлөмж өгч, нэгтгэсэн тайланд тусгуулах 6 саналыг YAГ-ын Аудитын 3-р газарт хүргүүлж ажилласан.

Аудитын тайланг дарга, Тэргүүлэх аудиторын тушаалаар баталгаажуулж YAГ болон аймгийн Засаг дарга, ИТХ-ын даргад 2021 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн 401, 402 тоот албан бичгээр тус тус хүргүүлсэн. Мөн иргэд олон нийтийг мэдээллээр хангах зорилгоор аудитын тайланг audit.mn сайтад байршуулж ажиллалаа.

Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд төлөвлөлтийн хангалтгүй байдал нөлөөлж байна гэж дүгнэлээ.



Орон нутгийн төсвийн 2019-2020 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг

Аудитын дүн



2.7 тэрбум төгрөг
73 төсөл, арга хэмжээ



Төсөл, арга хэмжээний
гүйцэтгэл **100.0%**



1,967.8 сая төгрөг
Илрүүлсэн алдаа
ЗӨРЧИЛ



Албан шаардлага
1,967.8 сая төгрөг
Зөвлөмжийн тоо **3**

Газрын даргын баталсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу “Орон нутгийн төсвийн 2019-2020 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг”-т хийх аудитыг 2020 оны 03 дугаар сарын 18-наас 05 дугаар сарын 28-ны өдрийн хугацаанд хийж гүйцэтгэлээ.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар Дорнод аймагт 2019 онд 1,431.2 сая төгрөгийн өртөгтэй 41 төсөл, арга хэмжээ, 2020 онд 1,285.9 сая төгрөгийн 32 төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр баталж хэрэгжүүлсэн байна.

Аудитад аймгийн ЗДТГ-ын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс, Санхүү төрийн сангийн хэлтэс, Орон нутгийн өмчийн газар, аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар, Санхүүгийн хяналт, аудитын алба, 13 сумдын ЗДТГ болон холбогдох байгууллагууд хамрагдлаа.

Аудитад 23.5 сая төгрөгийн өртөг, 228 хүн/өдөр зарцуулан, судалгаа, шинжилгээ хийх, ярилцлага, санал асуулга авах, тодруулга, тулган баталгаажуулалт хийх зэрэг горимуудыг хэрэгжүүлсэн.

Аудитаар нийт 1,967.8 сая төгрөгийн зөрчил илэрснээс 1,967.8 сая төгрөгийн зөрчил арилгах 6 албан шаардлага, 3 зөвлөмж өгч ажиллалаа.

Аудитын тайланг шалгагдагч байгууллага болох аймгийн Засаг дарга, хувийг ИТХ-д 2021 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн 415 тоот албан бичгээр хүргүүлсэн.

Мөн иргэд олон нийтийг мэдээллээр хангах зорилгоор аудитын тайланг audit.mn сайтад байршуулж ажиллалаа.

Орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд төлөвлөлтийн хангалтгүй байдал, дотоод хяналт сул байгаа нь нөлөөлж байна гэж дүгнэлээ.



4. НИЙЦЛИЙН АУДИТ

Төрийн аудитын газар нь шалгагдагч байгууллагын үйл ажиллагаанд мөрдөж байгаа төрийн санхүү, төсөв, нийтийн өмчтэй холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн актын хэрэгжилт, тэдгээрийн нийцэлд нийцлийн аудит хийж, 12.0 сая төгрөгийн өртөг 165 хүн/өдөр зарцууллаа.


ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ



1
Аудит
гүйцэтгэсэн



16
Байгууллагыг
хамруулсан



Эх сурвалж: Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын 2021 оны 2 дугаар улирлын статистик мэдээ

Нийцлийн аудитын үр дүн

МУЕА-ын баталсан аудитын төлөвлөгөөний хүрээнд 2021 онд 2 нийцлийн аудитыг хийхээр төлөвлөснөөс эхний хагас жилд батлагдсан 1 нийцлийн аудитыг 16 байгууллагыг хамруулан 100.0 хувь хугацаанд нь хийж гүйцэтгэлээ.

Нийцлийн аудитаар нийт 817.0 сая төгрөгийн зөрчил илрүүлж 568.0 сая төгрөгийн зөрчилд 6 албан шаардлага, 249.0 сая төгрөгийн зөрчилд 3 зөвлөмж өгч ажиллалаа.

Төрийн аудитын газраас нийцлийн аудитаар тайлант онд өгсөн 3 , өмнөх оны үлдэгдэл 8 нийт 11 зөвлөмжөөс 4 нь хэрэгжиж, хугацаа болоогүй 7 зөвлөмжийн үлдэгдэлтэй байна.

Өмнөх оны үлдэгдэл 5,620.6 сая төгрөгийн төлбөрийн актаас 2021 оны эхний хагас жилийн байдлаар 11.5 сая төгрөгийн төлбөрийн актыг барагдуулж, 5,603.8 сая төгрөгийн төлбөрийн актыг Прокурорын байгууллагад шилжүүлсэн бөгөөд 5.3 сая төгрөгийн төлбөрийн актын үлдэгдэлтэй байна.

Мөн тайлант онд өгсөн 6, өмнөх оны үлдэгдэл 5 нийт 11 албан шаардлагаас 5 албан шаардлага хэрэгжиж, 6 албан шаардлагын хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй байна.

Нийцлийн аудитын үр нөлөө

Газрын бодлого, шийдвэрийн хүрээнд өөрийн төлөвлөгөөгөөр иргэн, хуулийн этгээдэд газар эзэмшүүлэх, ашиглуулах шийдвэр, үйл ажиллагаа нь Газрын тухай хуульд нийцсэн эсэхэд нийцлийн аудит хийж газар эзэмшүүлэх, ашиглуулах үйл ажиллагаа, шийдвэрийг нотлох баримтад түшиглэн тайлагнаж, дүгнэлт, зөвлөмжийг холбогдох байгууллагад хүргүүлэн ажиллалаа.

Аймаг, сумдын Засаг дарга нарын 2019-2020 оны газар олголттой холбоотой гаргасан захирамжуудыг тулган шалгаж, холбогдох асуудлаар газрын даамлуудтай ярилцлага хийсэн.

Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг бүрэн мөрдөж ажиллаагүй тухай дүгнэлтийг гаргасан.

Нийцлийн аудитаар нийт 817.0 сая төгрөгийн үр өгөөжийг бүртгэн, шалгагдагч байгууллагаар хүлээн зөвшөөрүүлж баталгаажууллаа.

Иргэн, хуулийн этгээдэд газар эзэмшүүлэх, ашиглуулах шийдвэр, үйл ажиллагаа нь Газрын тухай хуульд нийцсэн эсэх



817.0 сая төгрөг
Илрүүлсэн алдаа
ЗӨРЧИЛ



Албан шаардлага **568.0** сая төгрөг
Зөвлөмж **249.0** сая төгрөг

Газрын даргын баталсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу “Иргэн, хуулийн этгээдэд газар эзэмшүүлэх, ашиглуулах шийдвэр, үйл ажиллагаа нь Газрын тухай хуульд нийцсэн эсэх”-т хийх аудитыг 2021 оны 03 дугаар сарын 09-өөс 05 дугаар сарын 28-ны өдрийн хугацаанд хийж гүйцэтгэлээ.

Аймгийн хэмжээнд 2019-2020 онуудад гэр бүлийнх нь хамтын хэрэгцээнд зориулан 229 нэгж талбарт 119.7 га газар, иргэн, хуулийн этгээдэд 150 нэгж талбарт 649.3 га газрыг тус тус эзэмшүүлсэн байна. Мөн ашиглалтаар 37 нэгж талбарт 1,233.4 га газрыг ашиглуулахаар олгосон байна.

Аудитад аймгийн ЗДТГ-ын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс, аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар, 14 сумдын ЗДТГ нийт 16 байгууллага хамрагдлаа.

Аудитад 12.0 сая төгрөгийн өртөг, 165 хүн/өдөр зарцуулан, судалгаа, шинжилгээ, ярилцлага хийх, тодруулга авах, тулган баталгаажуулалт хийх зэрэг горимуудыг хэрэгжүүлсэн.

Аудитын тайланг шалгагдагч байгууллага болох аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газарт 2021.05.28-ны өдрийн 417 тоот албан бичгээр, аймгийн Засаг дарга, хувийг ИТХ-д мөн өдрийн 418 тоот албан бичгээр хүргүүлж ажиллалаа.



Мөн иргэд олон нийтийг мэдээллээр хангах зорилгоор аудитын тайланг audit.mn сайтад байршуулж ажиллалаа.

5. НЭГДСЭН УДИРДАМЖААР ХИЙХ АУДИТЫН ТӨЛӨВЛӨЛТИЙН ӨМНӨХ ҮЕ ШАТ

1. "Хүнсний аюулгүй байдлыг хянах өнөөгийн тогтолцоо, төсвөөс зарцуулсан хөрөнгийн үр дүн"-д хийх гүйцэтгэлийн аудитын урьдчилсан судалгааны ажлын хүрээнд ҮАГ-аас зохион байгуулсан иргэний нийгмийн болон төрийн бус байгууллагын төлөөлөлтэй хийх цахим уулзалтад аудитын менежер, ахлах аудитор, аудиторуудыг оролцуулсан.

"Хүнсний аюулгүй байдлыг хянах өнөөгийн тогтолцоо, төсвөөс зарцуулсан хөрөнгийн үр дүн"-д хийх гүйцэтгэлийн аудитын төлөвлөлтийн өмнөх үе шатны ажлын хүрээнд аудитын урьдчилсан судалгаа хийх зорилгоор аймгийн Засаг даргын тамгын газраас ирүүлсэн хүнсний аюулгүй байдлыг хянах өнөөгийн тогтолцоо, тулгамдаж буй асуудал, цаашид тавих санал, тайлангуудад үнэлэлт, дүгнэлт хийж ажиллалаа.

Аудитын асуудлын шинжилгээнд оруулах 8 саналыг бэлтгэн 2021 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн 425 тоот албан бичгээр ҮАГ-ын 3-р газарт хүргүүлээд байна.

2. "Төрийн байгууллагуудын дотоод аудитын тогтолцоо, чиг үүргийн хэрэгжилт"-д хийх гүйцэтгэлийн аудитын төлөвлөлтийн үе шатны ажлаар аудитын урьдчилсан судалгаа хийх зорилгоор Санхүү хяналт, аудитын албаны үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт хийсэн.

Эрсдэлийн үнэлгээ, асуудлын шинжилгээнд тусгуулах 11 саналыг 2021 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн 416 тоот албан бичгээр ҮАГ-ын 3-р газарт хүргүүлсэн.

3. “Төрөөс эмийн талаар баримтлах бодлогын хэрэгжилт, үр нөлөө”-нд хийх гүйцэтгэлийн аудитын урьдчилсан судалгааны ажлын хүрээнд ҮАГ-аас зохион байгуулсан иргэний нийгмийн болон төрийн бус байгууллагын төлөөлөлтэй хийх цахим уулзалтад албан хаагчдыг оролцуулсан.

6. ӨӨРИЙН САНААЧИЛГААР ХИЙСЭН АУДИТ

ТАБ-ын 2021 оны эхний хагас жилд гүйцэтгэх аудитын төлөвлөгөөнд өөрийн төлөвлөгөөгөөр “ Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын 2019-2020 оны төлөвлөгөөний хэрэгжилт үр дүн”-д гүйцэтгэлийн аудит, “Газрын тухай хууль тогтоомжийн хэрэгжилт”-д нийцлийн аудит хийх санал хүргүүлж МУЕА-аар батлуулсан.

Гүйцэтгэлийн болон нийцлийн аудитыг төлөвлөгөөт хугацаанд бүрэн гүйцэтгэж тайланг дарга, Тэргүүлэх аудиторын тушаалаар баталгаажуулан холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлж ажилласан.

Аудитуудын талаарх мэдээллийг статистик мэдээний дүнтэй уялдуулан гүйцэтгэл, нийцлийн аудитын бүлэгт дэлгэрэнгүй тусгалаа.

7. ДОТООД АЖИЛ

Сургалт



Дотоод сургалт

Төрийн аудитын байгууллагын 2019-2024 оны стратеги төлөвлөгөөнд тусгагдсан “ Нийгмийн бүхий л салбарыг хамарсан өргөн хүрээний асуудалд үнэлэлт дүгнэлт өгөх мэдлэг, чадвар бүхий хүний нөөцийг бүрдүүлэх” зорилтын хүрээнд ажилтнуудын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд мэдлэг чадвараа дээшлүүлэх зорилгоор тусгасан арга хэмжээг харьцуулан судалж газрын 2021 оны дотоод сургалтын чиглэл, арга зүйг тодорхойллоо.

Сургалтын төлөвлөгөөг боловсруулахдаа албан хаагчдаас сургалтын хэрэгцээ шаардлагын судалгаа авч өмнө онд гүйцэтгэсэн аудитиудаар аудиторуудад чанарын хяналт хийх явцад гарсан асуудлуудыг үндэслэн 2021 онд хэрэгжүүлэх сургалтын сэдвүүдийг боловсруулан нийт 6 төрлийн сургалт зохион байгуулахаар дарга, Тэргүүлэх аудитораар батлуулсан. Эхний хагас жилийн байдлаар батлагдсан төлөвлөгөөний дагуу 4 сургалтыг зохион байгуулаад байна. Үүнд: Санхүүгийн аудитын албанаас "Хаан консалтинг" аудит ХХК -ны аудиторуудад 2021 оны 01 дүгээр сарын 08-нд “Санхүүгийн тайлангийн аудит” сэдэвт сургалтыг "Ковид-19" цар тахалтай холбоотойгоор онлайн хэлбэрээр, газрын аудиторуудад танхимаар зохион байгуулсан.

Дарга, Тэргүүлэх аудитор аудитын үйл ажиллагаанд 2021 онд шинээр мөрдөгдөх журам, зааврыг ашиглах арга зүй, аудитын чанарыг сайжруулахад анхаарах арга зүй, Удирдах ажилтны зөвлөгөөнөөр олж авсан мэдлэгийг түгээх зэрэг 3 сургалтуудыг зохион байгуулсан. Мөн шинээр томилогдсон аудитын менежерийг аудитын үе шатны ажил бүрт арга зүйгээр ханган ажиллаж, уншиж судлах зүйлийн жагсаалт гарган өгч , хууль, заавар журмуудын гарын авлагатай болгосон.

ҮАГ-аас хийсэн сургалт

ТАБ-ын хэмжээнд нэгдсэн байдлаар зохион байгуулагдсан сургалтуудад тухай бүр оролцон, өгсөн чиглэл арга зүйг хэрэгжүүлэн ажиллалаа.

Шилэн данс болон статистик мэдээний цахим бүртгэлийн систем болох Local.audit.mn сайтад ажиллах 3 удаагийн цахим сургалтад нийт албан хаагчид хамрагдаж мэдээлэл байршуулах үйл явцыг бүрэн эзэмшсэн. ҮАГ-ын 3 дугаар газраас зохион байгуулсан аудитын чиглэл арга зүй өгөх нийт 3 сургалтад нийт албан хаагчид бүрэн хамрагдлаа.

ТАБ-ын 2021 оны цахим сургалтыг зохион байгуулах төлөвлөгөөний дагуу шинээр томилогдсон аудитын менежер “Шинэ ажилтнуудад зориулсан цахим сургалт”-ын хөтөлбөрт хамрагдаж байна.

ТАБ-ын "Удирдах ажилтны зөвлөгөөн"-нд Тэргүүлэх аудитор оролцож "Аудитын төрлүүдийг хослуулан хөгжүүлэх бодлого чиглэл аудитын гүйцэтгэлийн чанарыг сайжруулахад анхаарах асуудал", ТАБ-ын байгууллагын албан хаагчийн ёс зүйн дүрэм” , "Хяналт-шинжилгээ үнэлгээ дотоод аудитын чиг үүрэг үйл ажиллагаа анхаарах зарим асуудал" зэрэг сэдвээр тавигдсан асуудлуудад санал дэвшүүлж амжилттай оролцлоо..

ҮАГ-аас цаг үеийн нөхцөл байдлаас шалтгаалж хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл болон аудитын үйл ажиллагаатай холбоотой арга зүйн сургалтуудыг цаг тухай бүрд нь өгч ажиллаж байгаа нь орон нутаг дахь байгууллагуудын бодлого, шийдвэр, тулгамдсан асуудлыг нэг арга зүйгээр ижил түвшинд шийдвэрлэх байдлыг нэмэгдүүлсэн үр дүнтэй ажил болж байна.

Бусад сургалт

Төрийн албаны зөвлөлөөс 7 хоног бүрийн Пүрэв гарагт зохион байгуулдаг салбар зөвлөлийн гишүүд, төрийн албан хаагчийн онлайн сургалтад Тэргүүлэх аудитор 21 удаа хамрагдсан.

Хамтын ажиллагаа



Төрийн аудитын байгууллагын 2019-2024 оны стратеги төлөвлөгөөнд тусгагдсан “Харилцагч талуудын үр ашигтай хамтын ажиллагааг дэмжиж, аудитын чанар, нийгэмд үзүүлэх үр өгөөжийг дээшлүүлэх” зорилтын хүрээнд хамтын ажиллагааг өргөжүүлж, бодит үр дүнг нэмэгдүүлэхээр дараах ажлуудыг зохион байгууллаа.

Газрын 2021 оны харилцагч талуудын оролцооны төлөвлөгөө боловсруулан батлуулж ажиллалаа.

Тайлант оны эхэнд аудитыг гүйцэтгэх баг бүрэлдэхүүн болон төсвийн захирагчид, санхүүгийн ажилтнуудыг оролцуулан аудитыг нээж, тухайн жилд өөрчлөгдсөн журам заавар, аудитад баримтлах чиглэл зарчмыг танилцуулж, аудитын үед хэрхэн хамтарч ажиллах талаар арга зүйн зөвлөмж өгч ажилласнаар шалгагдагч байгууллагууд аудитын үйл ажиллагааг дэмжиж, аудитаар илэрсэн алдаа зөрчлийг хүлээн зөвшөөрөхөд эерэг үр дүнгүүд гарч байна.

Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашигт хийгдэх аудитын төлөвлөлтийн үе шатны ажлын хүрээнд улс, орон нутгийн төсвөөс санхүүжилт авсан 55 аж ахуй нэгжийн орлого, зарлагын хуулгыг ХААН, ХАС, Төр, Голомт, Худалдаа хөгжлийн банкуудаар дамжуулан гаргуулж авч орон нутаг дахь банкны байгууллагуудтай хамтран ажилласан. Үүний үр дүнд гүйцэтгэгч компаниудын арилжааны банкин дахь дансны хуулгаас төсөл арга хэмжээний зардлыг зориулалтын дагуу зарцуулсан эсэхэд хяналт тавих боломж бүрдэж, үр дүнг аудитын тайланд тусгаж ажилласан.

Орон нутгийн хэвлэл, мэдээллийн байгууллагууд хэт өндөр дүнтэй гэрээ санал болгож байгаа тул татгалзаж, өөрсдийн төсвөөр бэлтгэсэн шинэ Canon 90D камераар дүрс бичлэг хийж ажиллаж байна. Өөрсдийн боловсруулсан мэдээллээ байгууллагын албан ёсны фэйсбүүк хуудсаараа дамжуулан иргэд олон нийтэд түгээн ажиллалаа. Байгууллагын албан ёсны фэйсбүүк хуудас болон audit.mn сайтаар аудитын нээлт, явц, дүн болон цаг үеийн шинж чанартай мэдээллийн талаар нийт 24 мэдээлэл түгээж 31823 иргэний хандалт авсан байна.

Төрийн аудитын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3.3-т “иргэд, олон нийтийн анхааралд байгаа үнэн зөв хариу хүссэн нийтийн ашиг сонирхлыг хөндсөн асуудал байх” гэсэн заалтын хүрээнд аудитын сэдвийн саналыг боловсруулахдаа иргэд олон нийтээс санал авах тухай видео мэдээллийг газрын фэйсбүүк хуудсанд байршуулж иргэд олон нийтийг аудитын үйл ажиллагаанд оролцох боломжийг бүрдүүлж ажиллаж байна.

Мэдээлэл сурталчилгаа



ТАБ-ын “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг хэрэгжүүлэх, төрийн аудитын байгууллагын идэвх оролцоог нэмэгдүүлэх замаар сайн засаглалыг дэмжих” стратегийн зорилтын хүрээнд төрийн аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийг

олон нийтэд ил тод мэдээлэх, байгууллагын үйл ажиллагааны талаар иргэдийг бодит мэдээллээр хангах чиглэлээр дараах ажлуудыг зохион байгуулж ажиллалаа.

Газрын 2021 оны аудитын үйл ажиллагаанд иргэдийн оролцоог хангах төлөвлөгөө, боловсруулан батлуулж хэрэгжүүлэн ажиллаж байна.

- “Улсын төсвийн 2020 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг”-т хийх гүйцэтгэлийн аудитын нээлтийг аймгийн Засаг даргын орлогч болон холбогдох газар, хэлтсийн удирдлага, мэргэжилтнүүд болон орон нутгийн ТВ-ийг оролцуулан хийж мэдээллийг audit.mn сайтад байршуулж ажиллалаа.
- “Газрын тухай хууль тогтоомжийн хэрэгжилт”-д хийх нийцлийн аудитын нээлтийг аймгийн Засаг дарга болон холбогдох алба, хэлтсийн удирдлага, мэргэжилтнүүд болон орон нутгийн ТВ-ийг оролцуулан хийж мэдээллийг audit.mn сайтад байршуулж ажиллалаа.
- ТШЗ, ТБОНӨААН, ТТЗ-дын байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитын дүн, цаашид анхаарах асуудлуудын талаарх мэдээллийг төсөв захирагчдын төрөл тус бүрээр буюу 3 удаа аймгийн удирдлагуудын шуурхай хуралдаан болон орон нутгийн ТВ-ээр мэдээлж ажиллалаа.
- Байгууллагын албан ёсны фэйсбүүк хуудас болон audit.mn сайтаар аудитын нээлт, явц, дүн болон цаг үеийн шинж чанартай мэдээллийн талаар нийт 24 мэдээлэл түгээж 31823 иргэний хандалт авсан байна.
- МУЕА-ын орлогчоор ажиллаж байсан О.Тэнгисийн өгсөн чиглэлийн дагуу аймгийн 2021 оны төсвийн төсөлд өгсөн санал дүгнэлтээр танилцуулга бэлтгэн 21 аймгийн Төрийн аудитад цахимаар танилцуулга илтгэл тавьсан. Аймгийн төсвийн төсөлд сүүлийн 3 жил өгсөн саналд дүн шинжилгээ хийж ҮАГ-ын Хөгжлийн бодлого төлөвлөлтийн газарт хүргүүлсэн. Орон нутгийн 2021 оны төсвийн төсөлд өгсөн санал дүгнэлтийн PPT хувилбарыг боловсруулж, аймгуудын Төрийн аудитын газруудад хүргүүлж ажилласан.

Албан харилцаа



Газрын хэмжээнд төлөвлөгдсөн албан бичгүүд, акт, албан шаардлагын утга найруулга болон хууль зүйн үндэслэл болон тушаалын төслүүдийн боловсруулалтад хяналт тавьж, аудит болон үйл ажиллагаанд тулгамдсан асуудлуудын талаар ҮАГ-ын Аудитын газрууд болон Тамгын газраас заавар, зөвлөмж авч ажиллалаа.

Газрын 2021 оны хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг гарган баталж, албан бичгийн бүртгэлийн цахим санг үүсгэн, албан бичгүүдийн шийдвэрлэлтэд бүртгэлээр хяналт тавьж хариуг хугацаанд нь өгч ажилласан.

2021 оны 6-р сарын 15-ны байдлаар цаасаар 1405 удаагийн 7874 хуудас, цахимаар 204 удаагийн 214 хуудас албан бичиг эргэлтэд орсноос, явсан бичиг 430, дарга, Тэргүүлэх аудиторын тушаал 11, төлбөрийн акт 67, албан шаардлага 388, хурлын тэмдэглэл 10, аудитын тайлан, гэрээ зэрэг бусад 141 албан бичиг хэвлэлтэд орж нийт 6750 хуудас хэвлэгдсэн байна.

Хүний нөөцтэй холбоотой судалгаа, мэдээ тайланг ҮАГ-аас ирүүлсэн чиглэлийн дагуу цаг тухай бүрд гарган заасан хугацаанд нь хүргүүлж ажиллалаа. Үүнд:

- Хүний нөөцийн хөдөлгөөн өөрчлөлтийн мэдээг сар бүрийн 20-нд ҮАГ-ын хүний нөөцийн мэргэжилтэнд хүргүүлж ажиллалаа.
- Ажилтнуудын албан тушаал, шагнал зэрэг болон бусад мэдээллийн талаарх судалгааг ирүүлсэн чиглэлийн дагуу тухай бүр гарган ҮАГ-ын холбогдох албан тушаалтнуудад цаг хугацаанд нь хүргүүлж ажилласан.
- Албан хаагчдын цалингийн тооцооллыг Төрийн аудитын тухай хууль, Төрийн албаны тухай хууль, бусад холбогдох дүрэм, журмын дагуу ТАЦНС-ээр гаргаж, цаг тухайд нь олгож байна.
- Газрын 2021 оны 1, 2 дугаар улирлын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг гаргаж ЗУГ-т хүргүүлсэн. Мөн 2 дугаар улирлын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг ХШУДАГ-аас ирүүлсэн маягтын дагуу гаргаж дарга, Тэргүүлэх аудиторын 06 дугаар сарын 15-ны өдрийн 432 тоот албан бичгээр дарга, Тэргүүлэх аудитор С.Энхбаатарт хүргүүлсэн.
- Шилэн дансны 2020 оны мэдээллийг цахим системд хугацаанд нь 100 хувь шивж дууссан.
- Статистик мэдээний бүртгэл нэгтгэлийн систем ашиглалтад орсонтой холбоотой 2019 оны эцсийн үлдэгдэл, 2020 оны мэдээллийг системд бүрэн шивж, 2021 оны мэдээллийг шивэх ажил 85 хувийн гүйцэтгэлтэй байна. МУЕА-ын баталсан 2018 оны А/235 дугаартай “Төрийн аудитын байгууллагын үйл ажиллагааны тайлан болон статистик мэдээг боловсруулж тайлагнах журам”-ын дагуу Газрын 2021 оны эхний хагас жилийн статистик мэдээг гарган дарга, Тэргүүлэх аудиторроор баталгаажуулж ажиллалаа.

Өргөдөл гомдол



Газрын хэмжээнд 2021 оны 06 дугаар сарын 15-ны байдлаар ирсэн нийт 7 өргөдлийг хуулийн хугацаанд нь шийдвэрлэж ажилласан. Төрлөөр нь авч үзвэл:

- Аудит хийлгэх хүсэлтэй -4
- Өмнөх оны санхүүгийн аудитын дүгнэлтийн хуулбар авахтай холбоотой -1
- Байгууллагын албан хаагчдаас ирүүлсэн - 2 байна.

Шагнал урамшуулал



ҮАГ-аас Covid19–н нөхцөл байдалтай холбогдуулан ирүүлсэн чиглэлийн дагуу 0-12 насны хүүхэдтэй болон эрүүл мэндийн шалтгаантай ажилтнуудад цалинтай чөлөө олгох, ажлын цагийг богиносгох асуудлуудыг шийдвэрлэн, ажлын өрөө, тасалгаануудад ариутгал хийх, ажилтнуудыг амны хаалтаар хангах, дархлааг дэмжин, витаминжуулах ажлуудыг зохион байгуулж 701.1 мянган төгрөгийг зарцуулаад байна.

“Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр”-ийг тохиолдуулан албан хаагчдын 18-аас доош насны 16 хүүхдэд 320.0 мянган төгрөгийн бэлэг өгсөн нь албан хаагчдын ажилдаа хандах хандлагад урам дэм боллоо.

МУЕА-ын өгсөн чиглэлийн дагуу үр бүтээлтэй Төрийн аудитын байгууллагад 14 жил тасралтгүй ажилласан ахлах аудитор Д.Нармандахыг Төрийн дээд одон медаль болох “Хөдөлмөрийн хүндэт” медальд тодорхойлсон материалыг ҮАГ-ын Тамгын дарга Ц.Ганболдод хүргүүлсэн.

Шинэ санаачилга



- Аймгийн 2021 оны төсвийн төсөлд өгсөн санал дүгнэлтээр танилцуулга бэлтгэн 21 аймгийн Төрийн аудитад цахимаар танилцуулга илтгэл тавьсан. Аймгийн төсвийн төсөлд сүүлийн 3 жил өгсөн саналд дүн шинжилгээ хийж ҮАГ-ын Хөгжлийн бодлого төлөвлөлтийн газарт хүргүүлсэн. Орон нутгийн 2021 оны төсвийн төсөлд өгсөн санал дүгнэлтийн PPT хувилбарыг боловсруулж, аймгуудын Төрийн аудитын газруудад хүргүүлж ажилласан.
- ТАБ-ын 2021 оны 1 дүгээр улирлын цахим сэтгүүлээр дамжуулан аудиторын хувийн зан чанар, мэдлэг ур чадвар, давуу сул талыг харгалзан аль тохирох төрөлд нь сонгон ажиллуулсан нь ажлын бүтээмжийг дээшлүүлж, хувь хүний ажилдаа хандах хандлагыг идэвхжүүлж, аудитын үр дүнд эерэгээр нөлөөлсөн сайн туршлагаа түгээн ажилласан.
- Дэлхий нийтийн өмнө тулгарсан цар тахлын нөхцөл байдалд ажилтнуудын ажиллах нөхцөлийг ханган, ажлын чанар үр дүнг бууруулахгүй ажиллах талаар ТАБ-ын удирдлагаас өгсөн чиглэлийг онцгой анхаарч цахим орчинд ажиллах нөхцөлийг бүрдүүлэн ажиллаж байна. “Төрийн аудитын

байгууллагаас аудит хийх хугацаанд коронавируст /COVID-19/ халдвараас урьдчилан сэргийлэх байгууллагын дотоод үйл ажиллагаанд мөрдөх журам” боловсруулан 2021 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн дарга, Тэргүүлэх аудиторын 03 тушаалаар баталгаажуулан мөрдөн ажиллаж байна.

Нууцын хадгалалт хамгаалалт



Төрийн болон албаны нууцын тухай хууль, Төрийн болон албаны нууцыг хамгаалах нийтлэг журмыг мөрдлөг болгон дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

- МУЕА-ын А/108 дугаар тушаалаар батлагдсан төрийн болон албаны нууцыг хамгаалах дотоод журмын дагуу нийт албан хаагчдаас нууцын баталгааг гаргуулан авсан.
- Аудитын менежерээр томилогдсон И.Сэмжидмаагийн төрийн болон албаны нууцтай танилцах эрхийн зөвшөөрөл хүссэн анкет, 3 үеийн намтар холбогдох баримт бичгүүдийг аймгийн Тагнуулын газарт хүргүүлж, Төрийн болон албаны 2 дугаар түвшний нууцтай танилцах эрхийг авч, ажлаас чөлөөлөгдсөн аудитын менежер В.Цэнгэлмаагийн нууцтай танилцах эрхийг цуцлуулж ажилласан.
- Санхүүгийн тайлангийн аудитаар Хилийн болон Зэвсэгт хүчний ангиудын тайланг баталгаажуулах албан хаагчдад нууцтай танилцах эрхийн түвшний нотолгоо гаргуулж ажилласан.Төрийн болон албаны нууцад хамааралтай Хилийн болон Зэвсэгт хүчний ангиудын 2020 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын баримтыг үдэж цэгцлэн архивын нэгж болгон сэйфэнд хадгалж байна.

Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх



- Ажилтнуудын ХАСХОМ-ийг хуульд заасан хугацаанд мэдүүлэх ажлыг зохион байгуулж, мэдүүлгийг meduuleg.iaac.mn сайтад бүрэн оруулж баталгаажууллаа. Авлигатай тэмцэх газрын 2020.04.23-ны өдрийн 05/5036 тоот албан бичгийн дагуу АТГ-ын даргын 2018 оны 121 дүгээр тушаалаар батлагдсан журмыг баримтлан ХАСХОМ, баталгааны маягт, бүртгэлийн дэвтэр, тайлан мэдээг архивт шилжүүлж ажиллалаа. Эхний хагас жилийн байдлаар аудитад ашиг сонирхлын зөрчил үүсээгүй.
- Хөдөлмөрийн дотоод журам, Ёс зүйн дүрэм, ажлын байрны тодорхойлолт, Эрүүгийн болон Авлигатай тэмцэх тухай хууль зэргийг дахин давтан судалж ажил, аудитдаа ашиглаж мөрдлөг болгон ажиллаж байна.

- Байгууллагын эрх бүхий албан тушаалтнуудын ХАСХОМ-ын мэдүүлэг, нэгтгэсэн тайланг хуулийн хугацаанд хянан цахим сайтад баталгаажуулсан. Аудитын явцад ашиг сонирхлын зөрчил 1 үүссэн тул ашиг сонирхлын зөрчил үүссэн тухай мэдэгдлийг дарга, Тэргүүлэх аудитор шийдвэрлэж, meduuleg.iaас.mn сайтад бүртгүүлсэн.
- Үндэсний аудитын газрын Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх авлигын эсрэг үйл ажиллагааны 2021 оны төлөвлөгөөний төсөлд 3 санал боловсруулж хүргүүлсэн.
- ТАБ-ын Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх авлигын эсрэг үйл ажиллагааны Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын 2021 оны төлөвлөгөөг боловсруулж батлуулсан. Төлөвлөгөөний биелэлтийг гаргаж 2021 оны 06 дугаар сарын 15-нд ҮАГ-ын хүний нөөцийн мэргэжилтэн П.Ундармаад цахимаар хүргүүлж ажиллалаа.

Цаг үеийн шинжтэй гүйцэтгэсэн нэмэлт ажлууд:



- МУЕА-ын баталсан “ТАБ-аас 2019-2020 онд санхүүгийн тайлангийн аудит хийх ерөнхий чиглэл”, 2020 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн 2986 албан тоотоор ирүүлсэн чиглэл, аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудиторовын баталсан “Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын 2020-2021 оны санхүүгийн тайланд аудит хийх ерөнхий бодлого, үйл ажиллагааны чиглэл”-ийг хэрэгжүүлэх ажлыг газрын хэмжээнд аудитын төлөвлөлтийн өмнөх үе шатнаас эхлэн зохион байгуулж ажиллалаа.
- МУЕА, газрын дарга, Тэргүүлэх аудиторовын баталсан чиглэлийн хүрээнд тухайн байгууллагад хамаарах эрсдэлүүдийн дагуу хэрэгжүүлэх 2127 горим, сорилыг хэрэгжүүлэн 76580.3 сая төгрөгийн 499 алдаа зөрчил илэрснийг аудитын тайланд тусган дүгнэлт зөвлөмж өгч ажилласан. Ерөнхий чиглэлийг хэрэгжүүлэх талаар зохион байгуулсан ажлын тайланг нэгтгэн гаргаж хүргүүлсэн.
- МУЕА-ын баталсан ТАБ-аас 2020-2021 оны СТА-д баримтлах ерөнхий чиглэлийн хэрэгжилтийг гаргаж, тайланг дараа онд хэрэгжүүлэх чиглэлд тусгуулах саналын хамт МУЕА-т хүргүүлсэн.
- "Хаан консалтинг аудит" ХХК-ийн гүйцэтгэсэн 54 санхүүгийн тайлангийн аудитад хийх чанарын хяналтыг СТАУС программаар 2 үе шаттайгаар гүйцэтгэж, үе шатны ажилбар бүрд арга зүйн зөвлөмж өгч, хяналтын хуудсаар баталгаажуулан, аудитыг хуульд заасан хугацаанд чанартай гүйцэтгүүлэх болон МУЕА-ын 2018 оны тушаалаар батлагдсан журмын заавал хэвлэх маягтуудад чанарын хяналтыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулан ажиллалаа.
- МУЕА-ын 2020 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн А/81 дүгээр тушаалаар батлагдсан “Санхүүгийн тайланд аудит хийх хуулийн этгээдийн ажлын гүйцэтгэлийг хянах, үнэлэх, баталгаажуулах журам”-ын дагуу үе шатны ажлын гүйцэтгэлд хийх чанарын үнэлгээний явц 30 хувьтай хийгдэж байна.

- Үндэсний аудитын газрын Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх авлигын эсрэг үйл ажиллагааны 2021 оны төлөвлөгөөний төсөлд 3 санал боловсруулж хүргүүлсэн.
- ТАБ-ын ажилтны Ёс зүйн дүрмийн төсөлд аудиторуудаас санал авч нэгтгэн ярилцаад МУЕА-ын 2017 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн А/165 тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан маягтын дагуу 1 саналыг 2021 оны 03 дугаар сарын 16-нд ҮАГ-ын Захиргаа удирдлагын газрын хуульч шинжээч В.Орхонд orkhonb@audit.gov.mn цахим хаягаар хүргүүлсэн.
- “Петро-Чайна дачин тамсаг” ХХК-ны нэхэмжлэлд хариуцагчаар ахлах аудитор Б.Батжаргалыг оролцуулахаар итгэмжлэл гаргаж, Дорнод аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд 2021 оны 04-р сарын 05-ны өдрийн 383, хариу тайлбар нотлох баримтуудыг 382 тоот албан бичгээр тус тус хүргүүлээд байна.
- МУЕА-аас өгсөн үүрэг чиглэлийг тухай бүр ажилтан албан хаагчдад танилцуулж хэрэгжүүлэн ажиллаж байна. 2021 оны 2 дугаар улирлын байдлаар МУЕА-ын гаргасан долоон А тушаал, нэг Б тушаалын хэрэгжилтийг гарган ажиллалаа. МУЕА-аас "Удирдах ажилтны семинар"-аар өгсөн 6-н үүрэг чиглэлийг тухай бүр хэрэгжүүлэн биелэлтийг гаргаж хүргүүлэн ажиллалаа.
- ҮАГ-аас өгсөн чиглэлийн дагуу байнга хэрэгжүүлэх 6 төрлийн мэдээ / Ковид-19 цар тахлын үед хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний биелэлтийг 7 хоног бүрийн Пүрэв гарагт, Ковид цар тахалтай холбоотой албан хаагчдын өвчлөлийн талаарх товч мэдээллийг 7 хоног бүрийн Даваа, Пүрэв гарагуудад, гүйцэтгэл нийцлийн аудитын хэрэгжилт явцын мэдээг 14 хоног тутам Лхагва гарагт, ТАГ-ын хураангуй болон Тэргүүлэх аудиторын тайланг 14 хоног тутам Лхагва гарагт, ТАГ-ын хүний нөөцийн хөдөлгөөний мэдээг сар бүрийн 20-нд, ТАГ-ын сарын товч тайланг сар бүрийн 25-нд / тайланг гарган хугацаанд нь хүргүүлэн ажиллаж байна.
- ТАБ-ын 2020 оны эхний хагас жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд хийсэн ХШҮ-ний тайлангаар өгөгдсөн 7 зөвлөмжийг хэрэгжүүлэн биелэлтийг ҮАГ-т 2021 оны 02 дугаар сарын 08-ны өдөр chimedlkhamb@audit.gov.mn цахим хаягаар хүргүүлж ажилласан.
- ТАБ-ын 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд хийсэн ХШҮ-ний тайлангаар өгөгдсөн 3 зөвлөмжийг хэрэгжүүлэн биелэлтийг ҮАГ-ын Хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор С.Энхбаатарт 2021 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн дарга, Тэргүүлэх аудиторын 430 тоот албан бичгээр хүргүүлж ажилласан.
- Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар төрийн албан хаагчийг хууль бусаар төрийн албанаас чөлөөлсний улмаас шүүхийн шийдвэрийн дагуу төсвөөс ажилгүй байсан хугацааны олговорт 21.9 сая төгрөгийг олгосон байна. Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1-д заасны дагуу төсөвт учруулсан хохирлыг барагдуулах арга хэмжээ авч ажиллах зөвлөмжийг аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын албанд дарга, Тэргүүлэх аудиторын 2021 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн 396 тоот албан бичгээр хүргүүлж ажилласан.
- Албан хаагчдаас Монгол Улсад төрийн хяналтын байгууллага үүсэн байгуулагдсаны 100 жилийн ойн бэлтгэл ажлын хүрээнд зохион байгуулах

ажлын төлөвлөгөөнд оруулах саналыг авч нэгтгэн 2021 оны 01 дүгээр сарын 28-нд erdenechuluunl@audit.gov.mn цахим хаягаар хүргүүлсэн.

- Газрын хэмжээнд Хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн мэдээллийн бүртгэл, судалгаатай болсон. 2021 оны 1 дүгээр улирлын байдлаар Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу "Гадаадаас ажиллах хүч авч ажиллуулахтай холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилт"-д хийсэн нийцлийн аудитаар "Шинь Шинь" ХХК нь 2020 онд хуульд заасан хувь хэмжээнээс илүү авч ажиллуулсан гадаад ажилтны ажлын байрны төлбөрийг төсөвт төлөөгүй зөрчил илэрсэн тул 237943968 / хоёр зуун гучин долоон сая есөн зуун дөчин гурван мянга есөн зуун жаран найман / төгрөгийг Дашбалбар сумын орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр акт тогтоосныг хугацаанд нь барагдуулаагүй тул аймгийн Прокурорын газарт хүргүүлээд байна. Одоо шүүхийн шатанд явж байна. Хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн мэдээллийн бүртгэл хөтлөн ажиллуулж байна.
- Аудитын үр өгөөжийг төлөвлөх, бүртгэх, тайлагнах, хянах, мэдээлэх журам-ыг шинэчлэн боловсруулахтай холбоотой саналыг албан хаагч бүрээс МУЕА-ын баталсан дотоод журмын хавсралт маягтын дагуу авч хэлэлцүүлж нэгтгэн МУЕА-ын орлогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Наранчимэгт дарга, Тэргүүлэх аудиторын 2021 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн 427 тоот албан бичгээр хүргүүлсэн.
- Санхүүгийн тайлангийн аудитад 2022 онд хамрагдах байгууллагуудын жагсаалт, аудит хийх хэлбэрийг А20101, А30101 маягтаар гарган ТА-ын 2021 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн 428 тоот албан бичгээр МУЕА-ын орлогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Наранчимэгт хүргүүлээд байна.
- ТАГ-ын 2021 оны харилцагч талуудын оролцооны төлөвлөгөөг боловсруулж дарга, Тэргүүлэх аудитораар батлуулж ажилласан.
- ТАГ-ын 2021 оны аудитын үйл ажиллагаанд иргэдийн оролцоог хангах төлөвлөгөөг боловсруулж дарга, Тэргүүлэх аудитораар батлуулж ажиллалаа.

Мэдээллийн технологи



Байгууллагын сервер, сүлжээ, компьютерын аюулгүй байдлыг ханган дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:

Үндэсний аудитын газраас вирусны эсрэг программын шинэчлэлтийг хийхгүй байх хугацаанд мэдээллийн аюулгүй байдлыг хангах үүднээс 1 сарын эрхтэй trial antivirus программ суулган ашигласан.

Зөөврийн хард, флаш ашиглахгүйгээр зөвхөн албаны мэйл хаягаар шалгагдагч талуудтай файл солилцож ажилласан.

Мөн аймгийн Харилцаа холбоо ТӨХК дээр байдаг router залгуур шатсан тул шинээр сольж байршуулсан.

Тайлант хугацаанд аудитын менежер болон 2 аудиторын компьютерын үйлдлийн системийг шинэчилсэн.

Үндэсний аудитын газраас ирүүлсэн 2 ширхэг laptop /зөөврийн компьютер/-ийг audit.local domain хаягт холбосон.

8. САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛ ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ



Тус газрын санхүүгийн бүртгэл, төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайланг Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт, Монгол Улсын Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Татвар болон нийгмийн даатгалын багц хууль, холбогдох журам зааврын дагуу аккрузель сууриар илэрхийлэн “Юникус” программаар гарган ажиллаж байна.

Шилэн дансны тухай хуульд заасан мэдээ мэдээллийг байршуулах календарчилсан төлөвлөгөө гарган ТА-аар батлуулж мэдээллийг хугацаанд нь үнэн зөв байршуулж буй эсэхэд хяналт тавьж ажиллаж ирсэн. Эхний хагас жилийн байдлаар бүтэн жилээр оруулах 5, улирал бүр оруулах 3, сар бүр оруулах 15 мэдээллийг байршуулаад байна.

Батлагдсан төсвийг эдийн засгийн ангиллаар, сар улирлын хуваарийн дагуу зарцуулж 6-р сарын байдлаар 253,658.1 мянган төгрөгийн батлагдсан төсвөөс 211,744.3 мянган төгрөгийг зарцуулсан нь 83.7 хувийн гүйцэтгэлтэй байна. Энэ нь албан хаагчдын 1, 2 дугаар улирлын урамшуулалт цалин олгогдоогүйтэй холбоотой болно.

КОД	ҮЗҮҮЛЭЛТ	БАТЛАГДСАН ТӨСӨВ	ГҮЙЦЭТГЭЛ
1220	Санхүүжилтийн орлого	253,658,100.00	211,744,260.79
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал	205,062,500.00	174,037,737.61
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгал	26,559,100.00	23,562,594.68
2103	Байр ашиглалттай холбоотой зардал	724,200.00	724,200.00
2104	Хангамж бараа материалын зардал	3,841,600.00	3,833,728.5
2107	Томилот, зочны зардал	3,806,400.00	1,576,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээ	10,684,300.00	7,110,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	900,000.00	900,000.00

Батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулж, байгууллагын хэвийн үйл ажиллагааг ханган ажиллаж байна. Цалин хөлс, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлээс бусад зардлыг 50 хувиар бууруулсан ч 2 дугаар улирлын байдлаар өр авлага үүсгээгүй ажиллаж байна. Байгууллагын үйл ажиллагааг хэвийн явуулахад шаардлагатай автомашины дугуй болон тээврийн хэрэгслийн даатгалын төлбөр, өмгөөллийн хөлс зэрэг асуудлыг шийдвэрлүүлэх хүсэлтийг УАГ-ын СХОХ-т хүргүүлж санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлүүлж ажилласан. Байгууллагын 2020 оны санхүүгийн тайланд аудит хийлгэж "ЗӨРЧИЛГҮЙ" санал дүгнэлт авсан. Газрын 2020 оны санхүүгийн тайланд хийсэн

аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлтийг 2021.06.08-ны өдрийн 429 тоот албан бичгээр Мишээл-Од аудит ХХК-д хүргүүлж ажиллалаа.

Татвар, нийгмийн даатгалын байгууллагатай хийх тооцоог сар бүр хугацаанд нь хийж тайлагнаж ирлээ.ажилласны үр дүнд 2021 оны 2 дугаар улирлын байдлаар өр авлагагүй ажилласан.

Дарга, Тэргүүлэх аудиторын “Тооллогын комисс томилох тухай “2021 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн 11 дугаартай тушаалаар эхний хагас жилийн хөрөнгийн тооллогыг хийж, Өмч хамгаалах зөвлөлийн хурлаар баталгаажуулсан.

Газрын 2022 оны төсвийн төслийг боловсруулж тооцоо судалгааны хамт УАГ-ын ЗУГ-ын санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Ц.Наранцэцэгт 2021 оны 5 дугаар сарын 21-ний өдөр хүргүүлсэн.

Сар бүрийн эхэнд төсвийн гүйцэтгэлийн мэдээ гаргаж, аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтсээр баталгаажуулан ерөнхий санхүүч О.Оюунсайханд цахимаар хүргүүлж ажилласан.

9. ДҮГНЭЛТ, ЦААШДЫН ЗОРИЛТ



ТАБ-ын хэмжээнд дэвшүүлсэн “ Аудитыг цахимжуулж нэгтгэн удирдах тогтолцоог бүрдүүлэн төлөвшүүлэх жил”-ийн зорилтыг хангаж, шинэчлэгдэн батлагдсан Төрийн аудитын тухай хууль, шинээр батлагдсан Төрийн аудитын Монгол Улсын стандарт, МУЕА-ын баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам", "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна.

Дорнод аймаг дахь ТАГ нь ТАБ-ын 2019-2024 оны стратегийн зорилтуудад нийцүүлэн боловсруулсан 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан 5 чиглэлийн хүрээний 68 арга хэмжээнээс эхний хагас жилийн байдлаар хэрэгжүүлэх 56 арга хэмжээг 100 хувь хэрэгжүүлж ажиллалаа.

Батлагдсан сэдвийн хүрээнд гүйцэтгэсэн төлөвлөгөөт аудитуудыг чанар, стандартын шаардлагад нийцүүлэн гүйцэтгэхэд анхаарч, чанарын хяналтыг хэрэгжүүлэн 174 аудитыг гүйцэтгэснээс нийт 5941,8 сая төгрөгийн үр өгөөжийг шалгагдагч байгууллагаар хүлээн зөвшөөрүүлсэн нь төсвөөс авсан санхүүжилтийн 1 төгрөг тутамд 28.1 төгрөгийн үр өгөөжийг бий болгосон байна.

Төрийн аудитын дээд байгууллага болох УАГ-аас санхүүгийн тайлангийн аудитад хэрэгжүүлэх ерөнхий чиглэлийг МУЕА-аар батлуулан, хэрэгжүүлэх арга зүйг дэлгэрэнгүй гарган ирүүлсэн нь аудитын чанарыг сайжруулах, орон нутаг дахь аудитын газрууд нэг бодлого, нэг арга зүйгээр аудитыг гүйцэтгэж, илэрсэн асуудлыг адил түвшинд шийдвэрлэх байдалд эерэг нөлөө үзүүлж байна.

Өөрийн байгууллагын үйл ажиллагааны үр дүн, үр нөлөөг сайжруулахын тулд хөрөнгө, санхүү болон хүний нөөцийг зөв зохистой удирдаж, өмнө нь хийж байсан аудитын болон дотоод зохион байгуулалтын ажлуудыг шинэ санаа, бүтээлч

хандлагаар шинэлэг хэлбэрээр хийхээр зорьж ажилласан нь тодорхой үр дүнд хүрч цаашдын ажилд урам өгч байна.

Аудитын урьдчилсан судалгааны ажлын хүрээнд тухайн сэдвээр иргэний нийгмийн болон төрийн бус байгууллагын төлөөлөлтэй цахим уулзалт зохион байгуулж, аудитад ашиглах шалгуур үзүүлэлт болох хууль, эрх зүйн актууд, урьдчилсан судалгаа болон холбогдох материалуудыг TEAMS нэгдсэн группэд байршуулсан нь бидэнд үр өгөөжөө өгсөн, маш үр дүнтэй шинэлэг үйл ажиллагаа болж байна.

ТАБ-ын 2021 оны зорилтын хүрээнд мэдээллийн нэгдсэн систем нэвтрүүлж “Бүртгэлийн, статистик мэдээний болон шилэн дансны мэдээний нэгтгэлийн программ”-ыг нэвтрүүлж байгаа нь ажлын ачаалал, цаг хугацаа хэмнэсэн цаг үеэ олсон арга хэмжээ болж байна гэж үзэж байна.

Дэлхий нийтийн өмнө тулгарсан цар тахлын нөхцөл байдалд ажилтнуудын ажиллах нөхцөлийг ханган, ажлын чанар үр дүнг бууруулахгүй байх талаар ТАБ-ын удирдлагаас өгсөн чиглэлийг онцгой анхаарч технологийн дэвшлийг ашиглан цахим орчинд ажиллах туршилтыг хамт олноороо амжилттай хэрэгжүүллээ.

Цаашид ТАБ-ын үйл ажиллагааг иргэд, олон нийтийн дунд сурталчлах, таниулах, суралцагч байгууллага, суралцагч хамт олон байх, салбарын хэмжээнд манлайлагч байх зорилтуудыг тавин хэрэгжүүлэн ажилласаар байна.

10. САНАЛ, САНААЧИЛГА:



Төрийн аудитын байгууллага, түүний дотор аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газрын чиг үүрэг, үйл ажиллагаанд бий болгох хэрэгцээ шаардлагын талаарх санал:

Орон нутаг дахь Төрийн аудитын газрууд нь аймгийн ИТХ-ын болон ИТХ-ын тэргүүлэгчдийн хуралдаанд төсөв мөнгөтэй холбоотой асуудал хэлэлцэх үед зөвлөх эрхтэй оролцдог байх нь Төрийн аудитын тухай хуулиар хүлээсэн үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэхэд үр дүн үзүүлэхээр байна. Ялангуяа төсөвт тодотгол хийх үед санал дүгнэлт хэлэх нь төсвийн тухай хууль, төрийн аудитын тухай хуулийн зорилгыг хангахад ач холбогдолтой гэж үзэж байна. Иймээс Орон нутаг дахь Төрийн аудитын газруудын өмнө хэрэгжүүлдэг байсан бодлогын чиг үүргийг сэргээх саналтай байна.

Төрийн аудитын байгууллагын хэмжээнд ойрын төлөвлөгөөнд тусгуулах санал, санаачилга:

Төрийн аудитын байгууллагын хэмжээнд орон нутгийн ирэх оны төсвийн төсөлд өгөх санал, дүгнэлт болон төсвийн гүйцэтгэлийн нэгтгэсэн тайланд хийх аудит нь хоорондоо уялдаатай цогц буюу нэг цикл ажил гэдэг логик утгыг бий болгох. Мөн дээрх 2 аудит, дүгнэлтийг хэрхэн хэрэгжүүлэх утга агуулга бүхий журам, заавар батлагдсан маягтай болох саналтай байна.